



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-3259
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.21 № 173
танай _____ ны № _____ т

┌ ЦЭРГИЙН ШТАБЫН ДАРГА ┐
Ч.ЭНХБАЯР ТАНАА

Төрийн аудитын газраас танай байгууллагын 2022 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсэн дүгнэлт, тайланг хүргүүлж байна.

Аудитаар 85,907.8 мянган төгрөгийн 4 зөвлөмж өгч ажиллалаа.

Аудитын шийдвэрийн хэрэгжилтийг 2023 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор бүрэн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана уу.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭ



006030168



БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган аймгийн Цэргийн штабын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БУА-2023/32/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.open.audit.mn	Булган аймаг дахь төрийн аудитын газрын дарга бөгөөд Тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ Утас: 7034-2580 Цахим хаяг: Erdeneb@audit.gov.mn
Булган аймаг 2023 он	Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 7034-2716 Цахим хаяг: enkhtsoodolj@audit.gov.mn
	Аудитор: Г.Цэрэнлхам Утас: 7034-2495 Цахим хаяг: Tserenlkhamg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	7
4. АУДИТЫН ТАЙЛАН	9
4.1 Ерөнхий зүйл	9
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	10
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	10
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
4.5.1 Завсрын аудитын талаар.....	11
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	11
5.1 Төлбөрийн акт	12
Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.....	12
5.2 Албан шаардлага	12
5.3 Зөвлөмж.....	12
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө



БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 172

танай _____ ны № _____ т

АЙМГИЙН ЦЭРГИЙН ШТАБЫН
ДАРГА Ч.ЭНХБАЯР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Булган аймгийн Цэргийн штабын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Булган аймгийн Цэргийн штабын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, Батлан хамгаалахын сайд Булган аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний дагуу аймгийн Засаг даргын А/465 дугаар захирамжаар "Цэргийн бэлтгэл" сургалтыг БХЯ, ЗХЖШ-тай хамтран зохион байгуулсан. Төвийн бүсийн 9 аймгуудын сумдын 90 Засаг даргын тамгын газрын дарга, Цэргийн штабын 14 дарга, офицер, БХЯ, ЗХЖШ-ын 6 төлөөлөл нийт 110 бие бүрэлдэхүүнийг хамруулсан байна.

Аудитын гол асуудал

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг хэрэгжүүлээгүй, Цэргийн албаны тухай хууль, Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтоолоор баталсан "аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дүрэм", Аймгийн Засаг даргын 2007 оны 01 дүгээр захирамж, Төрийн албан зөвлөлийн 2020 оны 100

006020204

дугаар тогтоол "Албан тушаалын тодорхойлолт"-ыг зөрчин штабын даргын гарын үсгээр дүйцүүлэхийн мөнгөн төлбөрийг захиран зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 18 дугаар зүйлийн 18.1 дахь заалттай тус тус нийцээгүй, "Тохиолдсон байх", "Иж бүрэн байх", "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Б.ЭРДЭНЭ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/Төгрөгөөр/	
Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	-	
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	18,655,762.00	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	18,655,762.00	
413	Өглөг	-	18,655,762.00	
4136	Бусад өглөг	-	18,655,762.00	
41361	Байгууллагад төлөх өглөг	-	18,655,762.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	-	(18,655,762.00)	
51	Засгийн газрын хувь оролцоо	-	(18,655,762.00)	
512	Хуримтлагдсан үр дүн	-	(18,655,762.00)	
51220	Тайлант үеийн үр дүн	-	(18,655,762.00)	
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	-	-	

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/Төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	137,580,623.00	135,165,006.00	
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	137,580,623.00	135,165,006.00	
120	Нийтлэг татварын бус орлого	137,580,623.00	135,165,006.00	
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	137,580,623.00	135,165,006.00	
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	122,580,623.00	135,165,006.00	
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	15,000,000.00	-	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	137,580,623.00	153,820,768.00	
21	УРСГАЛ ЗАРДАЛ	137,580,623.00	153,820,768.00	
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,603,080.00	153,820,768.00	
2104	Хангамж, бараа материалын зардал	3,156,000.00	-	
210401	Бичиг хэрэг	201,000.00	-	
210402	Тээвэр, шатахуун	2,955,000.00	-	
2105	Нормативт зардал	4,340,000.00	-	
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,580,000.00	-	
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	760,000.00	-	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,524,700.00	-	
210604	Урсгал засвар	8,524,700.00	-	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,582,380.00	153,820,768.00	
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,582,380.00	153,820,768.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,977,543.00	-	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	37,977,543.00	-	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,977,543.00	-	
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	(18,655,762.00)	
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	(18,655,762.00)	

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

			/Төгрөгөөр/	
Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он	
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	137,580,623.00	135,165,006.00	

12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	137,580,623.00	135,165,006.00
120	Нийтлэг татварын бус орлого	137,580,623.00	135,165,006.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	137,580,623.00	135,165,006.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	122,580,623.00	135,165,006.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	15,000,000.00	-
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	137,580,623.00	135,165,006.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	137,580,623.00	135,165,006.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	99,603,080.00	135,165,006.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,156,000.00	-
210401	Бичиг хэрэг	201,000.00	-
210402	Тээвэр, шатахуун	2,955,000.00	-
2105	Нормативт зардал	4,340,000.00	-
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,580,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	760,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,524,700.00	-
210604	Урсгал засвар	8,524,700.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,582,380.00	135,165,006.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	83,582,380.00	135,165,006.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	37,977,543.00	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	37,977,543.00	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	37,977,543.00	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

					/Төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	-	-
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
8	Тайлант үеийн үр дүн	-	-	(18,655,762.00)	(18,655,762.00)
9	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(18,655,762.00)	(18,655,762.00)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	140,000,000.00	135,165,006.00	4,834,994.00	96.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	140,000,000.00	135,165,006.00	4,834,994.00	96.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	140,000,000.00	135,165,006.00	4,834,994.00	96.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	140,000,000.00	135,165,006.00	4,834,994.00	96.5
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	140,000,000.00	135,165,006.00	4,834,994.00	96.5
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	140,000,000.00	135,165,006.00	4,834,994.00	96.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	140,000,000.00	135,165,006.00	4,834,994.00	96.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	140,000,000.00	135,165,006.00	(4,834,994.00)	132.5
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	4	4	-	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	3	3	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цэргийн штаб нь эрхэм зорилгоо “Батлан хамгаалахын хууль тогтоомжийн биелэлтийг орон нутагт хангах, хэрэгжүүлэх” гэж тодорхойлжээ.

Тайлант онд “Дайчилгааны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.2, Батлан хамгаалахын сайд Булган аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний дагуу аймгийн Засаг даргын А/465 дугаар захирамжаар “Цэргийн бэлтгэл” сургалтыг БХЯ, ЗХЖШ-тай хамтран зохион байгуулсан. Төвийн бүсийн 9 аймгуудын сумдын 90 Засаг даргын тамгын газрын дарга, Цэргийн штабын 14 дарга, офицер, БХЯ, ЗХЖШ-ын 6 төлөөлөл нийт 110 бие бүрэлдэхүүнийг хамруулсан онцлох үйл явдал болсон байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаандаа Цэргийн албаны тухай хууль, Монгол Улсын батлах хамгаалахын тухай хууль, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Төрийн хэмнэлтийн тухай, шилэн дансны тухай, Татварын багц, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан тогтоол, дүрэм журам, эрх бүхий албан тушаалтнуудын шийдвэрүүдийн хэрэгжилтийг ханган үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цэргийн штабын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цэргийн штабын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны А/424 дугаар захирамжаар баталсан бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. 2022 онд бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос өөрчлөлт ороогүй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	-	-	-
Үндсэн хөрөнгө	-	-	-
Нийт хөрөнгө	-	-	-
Өр төлбөр	-	18,655.76	18,655.76
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	-	(18,655.76)	(18,655.76)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	-	-	-

Дээрх хүснэгтээс харахад тайлант онд материаллаг өөрчлөлт гарсан данс нь богино хугацаат өр төлбөрийн данс өссөн байна.

Батлах хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй хангах зорилгоор аймгийн ИТХ-ын 2021 оны 05/04 дүгээр хуралдааны тогтоолоор батлагдсан төсвийг үндэслэн 85,000.0 мянган төгрөгийн автомашин худалдан авснаас үүдэж өр төлбөр үүссэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг цэргийн дүйцүүлэхийн төлбөрийн орлогоос 100,000.0 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаар зардлыг 140,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх батлан хамгаалахын судалгаа шинжилгээний хөтөлбөрийн зэвсэгт хүчнийг хөгжүүлэх арга хэмжээг санхүүжүүлэхээр 140,000.0 мянган төгрөгөөр баталсан байна. Гүйцэтгэлээр 135,165.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, батлан хамгаалахын яаманд 48,139.7 мянган төгрөгийг цэргийн албаны тухай хуулийн заасны дагуу төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Хөтөлбөр арга хэмжээ				
Нийт дүн			140,000.0	135,165.0	4,835.0	96.5
1	70603	82307	140,000.0	135,165.0	4,835.0	96.5

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цэргийн штабын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар

илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Цэрэнлхам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Цэргийн штабын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 9/11 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны батлагдсан төсвөөс 140,000.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 2,100.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 1,575.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тухайн байгууллага 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.2, 12.1.3 дахь заалтууд, 15 дугаар зүйлийн 15.1.2-15.1.7 дахь заалтуудад заасан хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна. Хуулийн 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

Худалдан авалтын анхан шатны баримтаас хөөн шалгаж, тулган баталгаажуулахад Хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1 дэх заалтыг зөрчин худалдан авах ажиллагааг 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр үнэлгээний хороог байгуулж эхлүүлсэн байна. Гэтэл Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн хөрөнгө оруулалтын батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр худалдан авалт хийсэн байна.

Хуулийн 20 дугаар зүйлийн тайлагнал, ил тод байдлын 20.5 -д заасан этгээд шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулсан боловч, 7 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны тухай хуульд заасан нийт 152 мэдээлэл мэдээлэхээс 7 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаанд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар Цэргийн албаны тухай хууль, Засгийн газрын 2004 оны 66 дугаар тогтоолоор баталсан "аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дүрэм", Аймгийн Засаг даргын 2007 оны 01 дүгээр захирамж, Төрийн албан зөвлөлийн 2020 оны 100 дугаар тогтоол "Албан тушаалын тодорхойлолт"-ыг зөрчин штабын даргын гарын үсгээр дүйцүүлэхийн мөнгөн төлбөрийг захиран зарцуулж байгааг тусгайлан авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 187,415.5 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 187,415.5 мянган төгрөгийн алдааг залруулсан. Үүнд:

- Улсын бүртгэлийн гэрчилгээгүй, төсвийн шууд захирагч биш тул үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаж тайлагнах, эрх зүйн орчин байхгүй байхад автомашин, принтер, хэвлэгч тоног төхөөрөмж бүртгэлд тусгасан байна. Мөн автомашины өр төлбөрийг хандиваар бүртгэж орлогод авч тайлагнасан,
- Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7.11.3 нэр, данс зөрүүтэй орлогыг мөнгөн гүйлгээний тайланд илүү тайлагнасан,
- Цэргийн дүйцүүлэхийн мөнгөн төлбөрийг ажил гүйлгээ бүрээр журнал, ерөнхий дэвтэрт тухай бүр цаг хугацааны дарааллаар нь бүртгэх бичилтийг хийж, тайлагнаагүй,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар" "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар", Булган аймгийн Засаг даргын А/424 дугаар захирамжаар баталсан НБББББ-ын

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

баримтлаагүй өглөгийн дансыг өглөгийн данстай харьцуулж алдаатай бичилт хийсэн,

Аудитаар нийт 85,907.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 85,907.8 мянган төгрөгийн 4 зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогдоогүй болно.

5.2 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй болно.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Орлогын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Эрдэнэбаярын Баттулгын төлбөр 889,125 төгрөг, 10 иргэний дүйцүүлэх мөнгөн төлбөрийн зөрүү 18,750 төгрөг Аймгийн Засаг даргын захирамжийн жагсаалтад ороогүй дансанд тушаагдсанд байна.

Өгсөн зөвлөмж: Цэргийн дүйцүүлэхийн төлбөрийн шалгуур хангасан иргэдийн төлбөрийг төвлөрүүлж байх.

2. Зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Зэвсэгт хүчний 234-р ангид өгсөн дэмжлэгийг Рийк лейк констракшин ХХК-д шилжүүлсэн, шилжүүлсэн хөрөнгийн орлогыг 2023 оны 2 дугаар сард бүртгэлд тусгасан авсан.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын өмнөөс өр төлөхгүй байх, нягтлан бодох бүртгэлийг үнэн зөв тайлагнаж хэвших,

3. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт: Худалдан авалтын анхан шатны баримтаас хөөн шалгаж, тулган баталгаажуулахад Худалдан авах ажиллагааг 2021 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр үнэлгээний хороог байгуулж эхлүүлсэн байна. Гэтэл Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн хөрөнгө оруулалтын батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдөр худалдан авалт хийсэн байна.

Өгсөн зөвлөмж: Худалдан авах ажиллагааг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд зохион байгуулж хэвших.

4. Төрийн хэмнэлтийн тухай хуультай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн системд 167 мэдээлэл байршуулахаас 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд мэдээлж хэвших.

3. Зардалтай холбоотой асуудал

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Автомашин, принтер, хэвлэгч тоног төхөөрөмж бүртгэлд тусгасан байна. Өр төлбөрийг хандиваар бүртгэж орлогод авч тайлагнасан..	1	86,599.8			1	86,599.8						
Төвлөрүүлэх орлогоор мөнгөн гүйлгээний тайланд илүү тусгасан.	1	2,022.5			1	2,022.5						
Ажил гүйлгээ бүрээр журнал, ерөнхий дэвтэрт тухай бүр цаг хугацааны дарааллаар нь бүртгэх бичилт хийгээгүй.	1	98,409.9			1	98,409.9						
Өглөгийн дансыг өглөгийн дантай харьцуулж алдаатай бичилт хийсэн.	1	383.3			1	383.3						
Дүн	1	187,415.5	-	-	1	187,415.5	-	-	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс								Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах				
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
													албан шаардлага
ЗХ-ний 234-р ангид өгсөн дэмжлэгийг Рийк лейк констракшин ХХК-д	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

шилжүүлсэн байна. Мөн ЗХ-ний 234-р анги шилжүүлсэн мөнгөн дүнд 2023 оны 2 сард орлогод авсан.												
Аймгийн Засаг даргын захирамжид ороогүй иргэдийн цэргийн дүйцүүлэхийн төлбөр дансанд төвлөрүүлсэн	1	907.8					1	907.8				
Дүн	1	907.8	-	-	-	-	1	907.8	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн системд 167 мэдээлэл байршуулахаас 7 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан.	1	-					1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагааг 2022 оны 12 дугаар сард хийсэн.	1	85,000.0					1	85,000.0
Дүн	1	85,000.0	-	-	-	-	1	85,000.0
Нийт дүн	2	85,000.0	-	-	-	-	2	85,000.0